



МОНГОЛЫН
ХӨРӨНГИЙН
БИРЖ

2018

4-Р САР

Э-сонин

57-р дугаар






Үнэт цаасны зах зээл

Зах зээлийн тойм


/2018.04.30-ны өдрийн байдлаар/

1. Арилжаа явагдсан өдөр	21
2. Нийт арилжааны үнийн дүн /төгрөг/	10,532,225,567
Хувьцаа	9,939,502,867
Засгийн газрын үнэт цаас /анхдагч/	
Засгийн газрын үнэт цаас /хоёрдогч/	592,722,700
Компанийн бонд /анхдагч/	0
Компанийн бонд /хоёрдогч/	0
3. Нийт арилжигдсан үнэт цаасны тоо ширхэг	265,717,734
Хувьцаа	30,551,939
Засгийн газрын үнэт цаас /анхдагч/	
Засгийн газрын үнэт цаас /хоёрдогч/	5,970
Компанийн бонд /анхдагч/	0
Компанийн бонд /хоёрдогч/	0
4. Нийт хийгдсэн хэлцлийн тоо	5,550


Зах зээлийн үнэлгээ




TOP-20 индекс



MSE A индекс



MSE B индекс



Бүртгэлтэй хувьцаат компани

1. Нийт компанийн тоо	218
100% төрийн өмчит	19
Төрийн өмчийн оролцоотой	12
Хувийн өмчийн	187
I ангилал	9
II ангилал	40
III ангилал	169

Гишүүн үнэт цаасны компани

1. Гишүүн Үнэт цаасны компанийн тоо	58
Брокер, Дилер	50
Андеррайтер	23
Хөрөнгө оруулалтын зөвлөх	13



Үнэт цаасны зах зээл

Арилжаанд идэвхтэй оролцсон үнэт цаасны гишүүн компаниуд

/2018.04.30-ны байдлаар/

Сим бол	Нэр	Үнэт цаас авсан		Үнэт цаас зарсан		Арилжааны дүн / авсан, зарсан/ (₮)
		Тоо ширхэг	Үнийн дүн (₮)	Тоо ширхэг	Үнийн дүн (₮)	
1	Гаүли ХХК	11,352,300	6,227,522,923.79	11,040,510	6,179,941,444.99	12,407,464,368.78
2	Дэлгэрхангай секьюритиз ХХК	71,523	756,097,525.00	66,792	747,091,230.00	1,503,188,755.00
3	БиДиСек ХК	1,224,279	445,028,589.84	1,662,880	496,021,979.64	941,050,569.48
4	Ти Ди Би Капитал ХХК	1,531,732	356,977,640.75	2,630,099	279,207,648.62	636,185,289.37
5	Ард секьюритиз ХХК	472,269	182,464,006.29	470,843	420,855,352.92	603,319,359.21
6	Бумбат-Алтай ХХК	2,094,413	224,813,166.98	3,028,526	278,575,611.31	503,388,778.29
7	Голомт Капитал ХХК	1,692,138	310,412,577.31	1,111,966	180,942,775.37	491,355,352.68
8	Стандарт инвестмент ХХК	454,674	129,997,688.12	2,850,731	236,224,214.11	366,221,902.23
9	Ард капитал групп ХХК	756,100	200,273,404.86	154,537	127,086,661.35	327,360,066.21
10	Мирэ Эссет Секьюритис Монгол ХХК	5,007,344	264,862,461.06	899,188	52,953,444.10	317,815,905.16
11	Новел инвестмент ХХК	423,115	108,899,078.41	1,672,258	128,577,052.15	237,476,130.56
12	Мирэ Эссет Секьюритис Монгол ХХК	3,870,937	170,149,936.23	853,141	38,398,587.70	208,548,523.93
13	Блүмсбюри секьюритис ХХК	146,230	93,101,285.51	979,307	77,545,194.81	170,646,480.32
14	Санар ХХК	72,951	4,765,897.00	218,709	114,086,441.00	118,852,338.00
15	Батс ХХК	290,614	60,320,378.64	1,053,594	46,840,079.22	107,160,457.86
16	Гранддевелопмент ХХК	8,063	5,042,881.42	394,557	95,527,729.75	100,570,611.17
17	Лайфтайм инвестмент ХХК	19,102	89,234,322.10	1,175	5,454,240.00	94,688,562.10
18	Евразиа капитал монголиа ХХК	67,664	19,325,363.00	39,413	57,327,689.00	76,653,052.00
19	Тэнгэр капитал ХХК	6,065	1,153,600.00	31,583	53,171,495.22	54,325,095.22
20	Блэкстоун интернэйшнл ХХК	326,855	51,296,804.12	0	0.00	51,296,804.12

Идэвхтэй арилжигдсан хувьцаа

/2018.04.30-ны байдлаар/

№	Сим- бол	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /₮/	Дээд Ханш	Доод Ханш	Өөрчлөлт /Нэгж/	Өөрчлөлт %/
1	MCH	МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО	10,348,111	6,109,835,177.73	590.43	590.43	0.00	0.00
2	TTL	ТАВАН ТОЛГОЙ	76,362	757,675,130.00	12,150.00	8,400.00	-1,390.00	-12.00
3	NEH	ДАРХАН НЭХИЙ	40,604	743,053,200.00	18,300.00	18,300.00	0.00	0.00
4	LEND	ЛЭНДМН БЭСБ	16,019,283	711,161,361.19	49.00	39.80	-4.20	-9.08
5	JIV	ЖИНСТ-УВС	275,793	441,471,339.00	1,850.00	1,500.00	-9.00	-0.53
6	APU	АПУ	653,081	410,430,943.07	680.00	550.12	-16.69	-2.58
7	GOV	ГОВЬ	7,810	172,396,640.00	23,500.00	20,000.00	-1,480.00	-6.30
8	BDS	БИ ДИ СЕК	89,648	107,564,327.00	1,250.00	1,050.00	-148.00	-12.33
9	RMC	РЕМИКОН	1,279,296	52,127,537.00	46.00	38.00	6.08	16.00
10	MNP	МОНГОЛ ШУУДАН	78,238	44,611,063.34	643.00	545.00	16.79	2.89
11	SUU	СҮҮ	179,946	38,787,612.00	238.00	200.00	-25.51	-11.05
12	JTB	ЖЕНКО ТУР БЮРО	451,536	35,428,178.80	85.00	75.00	11.90	16.30
13	TCK	ТАЛХ ЧИХЭР	945	21,535,380.00	24,000.00	22,100.00	-280.00	-1.20
14	ITLS	АЙГҮҮЛС	164,834	21,440,451.30	135.00	125.00	0.00	0.00
15	MRX	МЕРЕКС	566,146	20,113,826.21	44.05	30.00	-5.50	-14.10
16	TAH	ТАХЬ-КО	1,124	17,985,000.00	17,000.00	16,000.00	-2,000.00	-11.11
17	JLT	НОГООН ХӨГЖИЛ ҮНДЭСНИЙ НЭГДЭЛ	80,342	15,947,921.15	261.45	130.00	73.00	50.34
18	HGN	ХӨХ ГАН	116,817	12,395,264.60	120.00	90.00	10.00	11.11
19	GTL	ГУТАЛ	646	12,357,200.00	21,260.00	18,500.00	500.00	2.63
20	UID	УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР	17,924	9,623,206.00	590.00	485.00	16.98	3.48



Үнэт цаасны зах зээл

Ханшийн өсөлттэй хувьцаа

/2018.04.30-ны байдлаар/

№	Үнэт цаас нэр	Арилжигдсан /Ширхэг/	Хаалтын ханш		Ханшийн өөрчлөлт /₮/	Өөрчлөлт %/
			2018-04-01	2018-04-31		
1	НОГООН ХӨГЖИЛ ҮНДЭСНИЙ	80,342	145	218.00	73.00	50.34
2	СИЛК НЕТ	50	555	734.57	179.12	32.25
3	ДАРХАН ГУРИЛ ТЭЖЭЭЛ	12	518	684.39	166.88	32.25
4	СОНСГОЛОН БАРМАТ	15	821	1,086.00	264.73	32.23
5	ЕВРОАЗИА КАПИТАЛ ХОЛДИНГ	22	768	1,010.00	242.09	31.53
6	БӨӨНИЙ ХУДАЛДАА ХК	1,605	341	419.00	78.00	22.87
7	АВТО ИМПЕКС	569	2,100	2,500.00	400.00	19.05
8	МОНИНЖБАР	20,010	149	175.00	26.00	17.45
9	ЖЕНКО ТУР БЮРО	451,536	73	84.91	11.90	16.30
10	РЕМИКОН	1,279,296	38	44.08	6.08	16.00
11	МОН НАБ	20	3,500	4,025.00	525.00	15.00
12	ХҮННҮ МЕНЕЖМЕНТ	6	94	107.88	14.07	15.00
13	АЗЫК	5	2,585	2,972.00	387.00	14.97
14	ЭРДЭНЭТ ЗАНДАН	4	1,719	1,976.00	257.00	14.95
15	ЖУУЛЧИН ГОВЬ	11	6,950	7,800.00	850.00	12.23
16	БАЯН-АЛДАР	593	580	650.00	70.00	12.07
17	ХӨХ ГАН	116,817	90	100.00	10.00	11.11
18	ДӨРВӨН-УУЛ	89	1,950	2,150.00	200.00	10.26
19	БҮТЭЭЛЧ ҮЙЛС	90	1,449	1,596.00	147.00	10.14
20	ЭРДЭНЭТ АВТО ЗАМ	56	1,100	1,199.00	99.00	9.00

Ханшийн бууралттай хувьцаа

/2018.04.30-ны байдлаар/

№	Үнэт цаас нэр	Арилжигдсан / Ширхэг/	Хаалтын ханш (₮)		Ханшийн өөрчлөлт (₮)	Өөрчлөлт %
			2018-04-01	2018-04-31		
1	СОР	466	1,450	1,100.00	-350.00	-24.14
2	МОНГОЛ САВХИ	315	1,076	850.00	-226.00	-21.00
3	ИХ БАРИЛГА	701	4,100	3,300.00	-800.00	-19.51
4	УЛААНСАН	835	1,100	900.00	-200.00	-18.18
5	НЭХЭЭСГҮЙ ЭДЛЭЛ	16	2,499	2,125.00	-374.00	-14.97
6	ӨНДӨРХААН	5	11,240	9,600.00	-1,640.00	-14.59
7	БУЛГАН ГУРИЛ ТЭЖЭЭЛ	80	1,486	1,275.00	-211.00	-14.20
8	МЕРЕКС	566,146	39	33.50	-5.50	-14.10
9	МОНГОЛ НЭХМЭЛ	103	3,750	3,250.00	-500.00	-13.33
10	Э-ТРАНС ЛОЖИСТИКС	600	115	100.00	-15.00	-13.04
11	БИ ДИ СЕК	89,648	1,200	1,052.00	-148.00	-12.33
12	ТАВАН ТОЛГОЙ	76,362	11,580	10,190.00	-1,390.00	-12.00
13	ЖУУЛЧИН ДЮТИ ФРИЙ	58	113,600	100,500.00	-13,100.00	-11.53
14	ТАХЬ-КО	1,124	18,000	16,000.00	-2,000.00	-11.11
15	СҮҮ	179,946	231	205.36	-25.51	-11.05



ҮНЭТ ЦААСАА ДАВХАР БҮРТГҮҮЛЭХЭЭР ХҮСЭЛТ ГАРГАСАН КОМПАНИЙН ҮНЭТ ЦААСЫГ МХБ-ИЙН БҮРТГЭЛД БҮРТГЭЛЭЭ

Канад улсын Торонтогийн хөрөнгийн биржид бүртгэлтэй компани "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-д үнэт цаасаа давхар бүртгүүлж, үнэт цаасаа нийтэд санал болгох хүсэлтийг 2018 оны 3 дугаар сарын 12-ны өдөр ирүүлсэнтэй холбогдуулан МХБ-ийн Гүйцэтгэх захирлын 2018 оны 4 дүгээр сарын 4-ний өдрийн А/48 дугаар тушаалаар тус компанийн Монгол улсад нийтэд санал болгон гаргаж байгаа 1.2 сая канад долларын үнийн дүн бүхий 4,000,000 / дөрвөн сая/ хүртэлх ширхэг үнэт цаасыг МХБ-ийн хувьцааны бүртгэлийн III ангилалд бүртгэлээ. Санхүүгийн Зохицуулах Хороо тус хүсэлтийг шалгаж дууссаны дараа бид давхар бүртгэгдсэн үнэт цаасны талаар олон нийтэд мэдээлэх болно.

"ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА" ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй "Хөвсгөл Алтан Дуулга" ХК нь 2018 оны 4 дүгээр сарын 02-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаараа "Компани нэмж хувьцаа гарган олон нийтэд санал болгох, Төлөөлөн удирдах зөвлөлд зарим бүрэн эрх олгох тухай" гэсэн 2 дугаартай шийдвэрээр Компанийн тухай хуулийн 87.1.2-т заасан их хэмжээний хэлцэл буюу 4,405,600 ширхэг энгийн хувьцаа нэмж гарган, олон нийтэд санал болгохоор шийдвэрлэв. Энэхүү шийдвэр гаргах санал хураалтад оролцоогүй, эсхүл эсрэг саналтай байсан хувьцаа эзэмшигчид Компанийн тухай хуулийн 53, 54 дүгээр зүйлд заасны дагуу өөрийн эзэмшлийн хувьцааг эргүүлэн худалдаж авахыг компаниас шаардах эрх үүссэн болно.

Иймд "Хөвсгөл алтан дуулга" ХК-ийн шаардах эрх нь үүссэн хувьцаа эзэмшигчид уг эрхээ хэрэгжүүлэх хүсэлтэй бол "Хөвсгөл алтан дуулга" ХК болон андеррайтер "Бумбат-Алтай ҮЦК" ХХК-д хандана уу.

Хувьцаагаа эргүүлэн худалдан авахыг шаардах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийн огноо:

2018 оны 4-р сарын 02-ны өдөр

Хувьцаагаа эргүүлэн худалдан авахыг шаардах эрх дуусах огноо:

2018 оны 5-р сарын 17-ны өдрийг хүртэл

Шаардах эрхийг хэрэгжүүлэх нэгж хувьцааны үнэ: **8095 төгрөг**

Шаардах эрх хэрэгжүүлэгч "Хөвсгөл алтан дуулга" ХК: УБ, СБД, 8-р хороо, 11-р хороолол, Ж.Батмөнхийн гудамж, 39-2 Финтек оффис 8-р давхар, Холбогдох утас: 99986083, 99165186

"Бумбат-Алтай ҮЦК" ХХК: УБ, ЧД, 4-р хороо, 16-р байр 4 давхар, 41 тоот, Холбогдох утас: 70112166, 91005585

ҮНЭТ ЦААС ГАРГАХ ХҮСЭЛТЭЙ КОМПАНИУДАД ЗОРИУЛСАН УУЛЗАЛТЫН ЦАГ АВАХ ЦЭСИЙГ МХБ-ИЙН ЦАХИМ ХУУДСАНД БАЙРШУУЛЛАА

Монголын хөрөнгийн зах зээл сүүлийн жилүүдэд идэвхжиж, үнэт цаасаа гаргаж хөрөнгө босгох сонирхолтой аж ахуйн нэгжүүдийн тоо нэмэгдэж байгаа нь 2017 оны арилжааны дүн болон индексүүдийн өсөлтөөс харагдаж байна. Түүнчлэн, сүүлийн хагас жилд Монголын хөрөнгийн биржид бүртгүүлж, анхдагч зах зээлд хувьцаагаа олон нийтэд санал болгох замаар хөрөнгө босгосон компаниудын үнэт цаасны худалдан авах захиалга нийлүүлэлтээсээ 3-16.5 дахин их байсан нь шинэ бүтээгдэхүүний эрэлт өндөр байгааг харууллаа.

Иймд МХБ-ээс үнэт цаас гаргахыг сонирхсон аж ахуйн нэгжүүдтэй ганцаарчлан уулзаж мэдээлэл өгөх зорилгоор МХБ-ийн цахим хуудсанд "Цаг авах" шинэ цэс үүсгэлээ. Үнэт цаас гаргах хүсэлтэй аж ахуйн нэгжүүд энэхүү цэсийг ашиглан ажлын өдөр бүрийн 11.00 цагаас уулзалт товлон боломжтой бөгөөд бизнес эрхлэгч, аж ахуйн нэгж компаниуд та бүхэн бидэнтэй уулзаж, үнэт цаас гаргах талаар дэлгэрэнгүй мэдээлэл аваарай.



ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ НЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОН 8 ҮЦК-ИЙН ХАРИЛЦАГЧДЫГ ШИЛЖҮҮЛЛЭЭ

Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 4 дүгээр сарын 04-ний өдрийн хуралдаанаар үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл нь цуцлагдсан 8 үнэт цаасны компанийн харилцагчдыг дараах компаниудад шилжүүлэхээр шийдвэрлэсэн байна. Үүнд:

№	Тусгай зөвшөөрөл нь цуцлагдсан компанийн нэр	Харилцагч шилжүүлэн авсан үнэт цаасны компанийн нэр
1	"Ай трейд ҮЦК" ХХК	"Бумбат-Алтай" ҮЦК
2	"Эм Даблю Ти Эс ҮЦК" ХХК	
3	"Финанс линк групп ҮЦК" ХХК	
4	"Говийн ноён нуруу ҮЦК" ХХК	
5	"Превалент ҮЦК" ХХК	
6	"Би Би Эс Эс ҮЦК" ХХК	"Би Ди Сек ҮЦК" ХК
7	"Зюс капитал ҮЦК" ХХК	
8	"Бага хээр ҮЦК" ХХК	
		"Өндөрхаан инвест ҮЦК" ХХК

Тусгай зөвшөөрөл нь хүчингүй болсон дээрх 8 үнэт цаасны компанийн харилцагчид нэмэлт төлбөр, зардал чирэгдэлгүйгээр үнэт цаасны дансаа үргэлжлүүлэн эзэмшиж, хөрөнгийн зах зээлийн харилцаанд саадгүй оролцох боломжтой юм.

"ЛЭНДМН ББСБ" ХК НЬ ХУВЬЦААГАА ЭРГҮҮЛЭН ХУДАЛДАЖ АВАХ АСУУДЛЫГ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛЫН ЖАГСААЛТААС ХАСЛАА

"Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-д бүртгэлтэй "ЛэндМН ББСБ" ХК нь хувьцаа эзэмшигчийн ээлжит бус хурлаа 2018 оны 5 дугаар сарын 10-ны өдөр хуралдуулахаар зарласан ба уг хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтанд "Компани өөрийн хувьцаагаа эргүүлэн худалдан авах эрхийг зөвшөөрөх эсэх" асуудлыг тусгасан байсан.

Компанийн тухай хуулийн 33.7-д заасны дагуу, компани өөрийн гаргасан хувьцааг эргүүлэн худалдан авсан тохиолдолд тус хувьцаа нь компанийн зарласан боловч гаргаагүй хувьцаанд тооцогдох ба ийнхүү гаргасан хувьцааны тоог бууруулах нь МХБ-ийн үнэт цаасны бүртгэлийн III ангиллын шалгуурыг үл хангах нөхцөл үүсэх тухай "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-иас "ЛэндМН ББСБ"

ХК-д албан бичгээр мэдэгдсэний дагуу уг асуудлыг 2018 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтаас хассан байна.

"МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО" ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН БҮРТГЭЛД ӨӨРЧЛӨЛТ ОРЛОО

Монгол Улсын Засгийн Газар болон БНСУ-ын "Кореа Телеком" ХК-ийн хооронд байгуулагдсан гэрээний дагуу Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй "Монголын Цахилгаан Холбоо" ХК-ийн 40 хувийг Монгол Улсын Засгийн газарт худалдах багцын арилжаа 2018 оны 4 дүгээр сарын 18-ны өдөр явагдсанаар тус компани дахь Монгол Улсын Засгийн газрын эзэмшлийн хувь 94.67 хувьд хүрлээ.

"ХҮРД" ХК НОГДОЛ АШИГ ТАРААХААР БОЛЛОО

МХБ-ийн үнэт цаасны III ангилалд бүртгэлтэй "Хүрд" ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2018 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн №03 тоот тогтоолоор компанийн 2017 оны цэвэр ашгийн дүнгээс нийт 67.2 сая төгрөг буюу нэгж хувьцаанд 497 төгрөгийн ногдол ашгийг хуваарилахаар шийдвэрлэсэн байна.

Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийн өдрийг 2018 оны 2 дугаар сарын 23-ны өдрөөр тогтоож, ноогдол ашгийг 2018 оны 2-р улиралд багтаан олгохоор болсон байна.

"АТАР ӨРГӨӨ" ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

Хан-Уул дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2018 оны 4-р сарын 23-ны өдрийн 183/ШЗ2018/05104 тоот захирамжийн дагуу "Таван богд трейд" ХХК, "Улаанбаатар гурил" ХХК нарын нэхэмжлэхтэй, "Атар өргөө" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлд холбогдох иргэний хэргийг эцэслэн шийдвэрлэх хүртэлх хугацаанд "Атар өргөө" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны 3 дугаар сарын 19-ний өдрийн 14 тоот тогтоолын биелэлтийг түдгэлзүүлэхээр болсон тул тус компанийн 2018 оны 4 дүгээр сарын 27-ны өдөр зарлагдсан хувьцаа эзэмшигчдийн хурлыг хойшлуулахаар болсон байна.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН



Монгол Улс, Улаанбаатар
хот 15160

Чингис Хааны талбай-3

Монголын Хөрөнгийн Бирж



+976 11-313747



+976 11-325170



Info@mse.mn



WWW.MSE.MN